



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 07 өдөр

Дугаар A/d53

Булган

Гэрээ байгуулах эрх
олгох тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралдааны 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 10/07 дугаар тогтоолын тавдугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн 2019 оны төлөвлөгөөнд тусгагдсан “Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, арчилгаа хийх” төсөл, арга хэмжээний зардлаас Баяннуур сумын Засаг дарга /Б.Ёндон/-д 2 000 000 /хоёр сая/ төгрөгийн эрх шилжүүлсүгэй.

2. Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, арчилгаа хийх үйл ажиллагааг холбогдох хууль, журам, гэрээний дагуу Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлын “Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, арчилгаа хийх” зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч /Б.Очирсүрэн/-д зөвшөөрсүгэй.

3. Эрх шилжүүлсэн хөрөнгийг хууль, журмын дагуу зохион байгуулж, гэрээ байгуулан гүйцэтгэлд нь тогтмол хяналт тавьж, чанарын өндөр түвшинд хүлээн авахыг Баяннуур сумын Засаг дарга /Б.Ёндон/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ

D:\ЗДТГ\ХОХБТХ\Захирамж

20190265